



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 13 өдөр

Дугаар A/11

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан зургаан иргэн, аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан гурван иргэн, аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Бест Тур ХХК "Гурван булаг" амралтын газрын 15/079, Уян Хайрхан ХХК "Мерри" зочид буудлын 13/207, Үндрүүл сифан ХХК "Үндрүүл" зочид буудлын 14/52, Иргэн Н.Түмэн-Өлзий "Өлзий" дэн буудлын 13/238, Кутэ ХХК "Чка" дэн буудлын 15/107, Иргэн Ч.Төрбат "Даниста Номадс" зочид буудлын 16/007, Уран Дриллинг ХХК "Десковери" зочид буудлын 13/228, Ашид Суврага ХХК "Ашид Эрдэнэ" зочид буудлын 13/231 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага олон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд

төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай..

6. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэд нь гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



D.Batsoy

Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 01 сарын 13
өдрийн дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



**ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ**


2017.01.23

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Үндруул Сифан ХХК	2094207	Үндруул	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, Их тойруу 24/3
2	Зүчи Хотел ХХК	5983886	Зүчи хотел	Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 25а
3	Ашид Суврага ХХК	5151406	Ашид-Эрдэнэ	Баянгол дүүрэг, 14-р хороо, Хасбаатарын гудамж 18/1
4	Өү Ди Ти Би ХХК	6102018	Дисковери	Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 49ж
5	Иргэн Ч.Төрбат	ЧА61062471	Даниста	Баянгол дүүрэг, 16-р хороо, Орхоны 1-37
6	Нарантуул Шилтгээн ХХК	5010675	Нарантуул	Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Энхтайваны өргөн чөлөө

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 01 сарын 13
өдрийн 11 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



**ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ**


2017.01.23

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрацийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Уян Хайрхан ХХК	2542838	Мерри	Налайх дүүрэг, 2-р хороо, Найрамдлын гудамж
2	Иргэн Н.Оюунбат	АЭ79042367	Чка	Баянзүрх дүүрэг, 5-р хороо, Б.Доржийн гудамж 83 тоот
3	Иргэн Н.Түмэн-Өлзий	ЧТ64120576	Өлзий	Баянзүрх дүүрэг, 6-р хороо, 13-р хороолол, 51-р байр

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 01 сарын 23
өдрийн 11 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.01.23

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Бест Түр ХХК	2094754	Гурван булаг	Баянзүрх дүүрэг, 20-р хороо, Гачуурт тосгон, Шар хоолойн дунд төгөл

-ооОо-